



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/201

Хэрлэн сум

Шагайн харвааны холбоонд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц, хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн “Шагайн харвааны холбоо”-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ